



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2013 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 249

Улаанбаатар хот

“Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцох журам”-ыг шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13.1.3, 14.2.2, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцох журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэ журмыг 2013 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
3. Тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 211 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцох журам”-ыг энэ тогтоолын 1-д заасан журам үйлчилж эхэлмэгц хүчингүй болсонд тооцсугай.
4. Батлагдсан журмын биелэлтэнд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х. Бум-Эрдэнэ/-д даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ЕРДИЙН ДААТГАГЧИЙН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫГ ТООЦОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь ердийн даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг компани /цаашид “даатгагч” гэх/-ийн даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлэхэд хүрэлцэхүйц хэмжээний хөрөнгөтэй эсэх, төлбөрийн чадвар нь зохих түвшинд хангагдсан эсэхийг тогтоож, хяналт тавихад оршино.

Хоёр. Төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт

2.1. Даатгагчийн төлбөрийн чадварын байдлыг тодорхойлохдоо төлбөрийн чадварын зохистой харьцаагаар тооцно.

2.2. “Төлбөрийн чадварын зохистой харьцаа”-г тооцохдоо даатгагчийн зөвшөөрөгдөх хөрөнгийн дүнгээс өр төлбөрийн дүнг хасч ялгаврыг зайлшгүй байх хөрөнгийн дүнд хувааж тооцно.

Төлбөрийн чадварын зохистой харьцаа = (Зөвшөөрөгдөх хөрөнгийн дүн - Өр төлбөрийн дүн) / Зайлшгүй байх хөрөнгийн дүн *100%

2.3. “Өр төлбөр” гэж тайлант хугацааны богино хугацаат өр төлбөр, урт хугацаат өр төлбөрийн нийлбэр дүнг хэлнэ. Өр төлбөрийг тооцохдоо богино хугацаат өр төлбөрийн хэсэг дэх орлогод тооцоогүй хураамжийн орлогыг 10 хувиар бууруулна.

2.4. Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа нь 100 хувь буюу түүнээс илүү байвал зохино.

2.5. Хэрэв даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа 100 хувиас доош байвал даатгагчийг төлбөрийн чадваргүй болсонд тооцно.

2.6. Даатгагчид зайлшгүй байх хөрөнгийн хэмжээг тооцохдоо дараах 3 үзүүлэлтийн хамгийн их дүнг үндэслэн тогтооно:

2.6.1. Агаарын хөлгийн, автотээврийн хэрэгслийн, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн орлогод тооцсон хураамжийн 40 хувь дээр бусад даатгалын хэлбэрийн орлогод тооцсон хураамжийн 20 хувийг нэмсэн дүн;

2.6.2. Агаарын хөлгийн, автотээврийн хэрэгслийн, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн сүүлийн 3 жилд нэхэмжилсэн хохирлын дундаж дүнгийн 50 хувь дээр бусад хэлбэрийн сүүлийн 3 жилд нэхэмжилсэн хохирлын дундаж дүнгийн 20 хувийг нэмсэн дүн

2.6.3. Хорооноос тогтоосон дүрмийн сангийн доод хэмжээ

2.7. Нэхэмжилсэн хохирлын дүнг гаргахдаа тухайн жилд олгосон нийт нөхөн төлбөрийн дүн дээр нэхэмжилсэн боловч олгоогүй хохирлын дүнг нэмж тооцно.

Гурав. Зөвшөөрөгдөх хөрөнгө ба өр төлбөр

3.1. Даатгагчийн зөвшөөрөгдөх хөрөнгө нь компанийн нийт хөрөнгийн дүнгээс зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүнг хассанаар тодорхойлогдоно. (Зөвшөөрөгдөх хөрөнгө = Нийт хөрөнгө - Зөвшөөрөгдөхгүй хөрөнгө)

3.2. Зөвшөөрөгдөхгүй хөрөнгө гэж даатгагчийн төлбөрийн чадварын үзүүлэлтэд сөргөөр нөлөөлж болохуйц хөрөнгүүдийг хэлэх ба дүнг дараах шаардлагыг харгалзан нэгдүгээр хавсралт “Маягт-1”-д дурьдсан аргачлалын дагуу тооцож тогтооно: */Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 498 дугаар тогтоолоор нэмэлт орсон/*

/Энэ заалтанд Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 343 дугаар тогтоолоор нэмэлт орсон/

Хөрөнгийн ангилал	Хөрөнгө байршуулах дээд хувь	Нэгжид ногдох хөрөнгийн дээд хувь	Зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн хувь
Баганын дүн	1	2	3
3.2.1 Банкны харилцах, хадгаламж <i>/Монгол банкнаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй банкинд байгаа харилцах хадгаламжийг ойлгоно./</i>	100%	35%	0%
3.2.1 ¹ Даатгалын үндсэн үйл ажиллагаанд зориулан авсан зээл	30%*	30%*	50%
3.2.2 Засгийн газраас гаргасан өрийн хэрэгсэл	100%	100%	0%
3.2.3 Банкны хадгаламжийн сертификат <i>/Иргэний хуулийн 454.3-д заасныг ойлгоно/</i>	50%	20%	0%
3.2.4 Төв банкны үнэт цаас <i>/Монголбанкны мөнгөний бодлогын нээлттэй захын хэрэгсэл бөгөөд хямдруулсан хэлбэрээр арилжигдаж, тогтоосон хугацааны дараа нэрлэсэн үнээр эргэн төлөгдөх үнэт цаасыг ойлгоно/;</i>	60%	60%	0%
3.2.5 Бэлэн мөнгө	2%	2%	0%
3.2.6 180 хоногоос доошхи хугацаатай авлага	20%	20%	0%
3.2.7 Санхүүгийн түрээс <i>/Санхүүгийн түрээсийн тухай хуулийн 3.1, 3.2-т заасныг ойлгоно/</i>	10%	5%	5%
3.2.8 Үл хөдлөх хөрөнгө <i>/Иргэний хуулийн 84.3 дахь хэсэгт заасан, холбогдох хууль, журмын дагуу баталгаажсан эрхийн гэрчилгээтэй үл хөдлөх хөрөнгийг хэлнэ. Аливаа зээлийн барьцаанд тавьсан, эсхүл төлбөрийн баталгаа болгосон хөрөнгийг үл хөдлөх хөрөнгөд оруулж тооцохгүй./</i>	25%	25%	5%

3.2.9 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас <i>/“Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлд заасныг ойлгоно/</i>		60%	20%	5%
3.2.10. Хөрөнгө оруулалтын сан /Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 6.2.1-д заасан нээлттэй, эсхүл хаалттай санг ойлгоно./ <i>/Энэхүү заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 279 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан.</i>		20%	10%	Нээлттэй сан: 5% Хаалттай сан: 10%
				10%
3.2.12 Компанийн өрийн хэрэгсэл <i>/Хорооноос тусгай зөвшөөрөл авсан даатгагчийн холбогдох этгээдээс бусад компанийн өрийн хэрэгслийг ойлгоно./</i>		20%	10%	10%
3.2.13 Эд хогшил тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслэл <i>/Даатгалын компанийн үндсэн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа биет үндсэн хөрөнгийг ойлгоно/</i>		10%	5%	90%
3.2.13 ¹ МХБ-ийн хувьцаат компанийн хувьцаа <i>/Энэхүү заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 279 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан.</i>	I ангилал	10%		20%
	II ангилал	5%	5%	30%
3.2.13 ² Тухайн даатгалын компанийн холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө <i>/Энэхүү заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 279 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан.</i>		20%	5%	5%
3.2.14 Бусад авлага		0%		100%
3.3.15 Биет бус хөрөнгө		0%		100%
3.2.16 Бараа материал		0%		100%
3.2.17 Урьдчилж төлсөн зардал		0%		100%
3.2.18 Бусад хөрөнгө <i>/Даатгагчийн балансын актив дахь нийт хөрөнгийн дүнгээс энэ хавсралтын 3.1-3.17-д заасан хөрөнгийг хасч тооцсон хөрөнгийн дүнг/</i>		0%		100%
Нийт дүн <i>/Даатгагчийн нийт хөрөнгө балансын актив дахь нийт хөрөнгийн дүнг ойлгоно/</i>				

*Хувь нийлүүлсэн хөрөнгө буюу дүрмийн сангийн хөрөнгөөс тооцно.

**Дөрөв. Холбогдох этгээд болон түүнтэй холбоотой этгээд буюу
хөрөнгө оруулалтын хязгаарлалт**

Даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан хязгаарлалтаас гадна дараах этгээдэд хөрөнгө оруулалт хийхийг хязгаарлах бөгөөд энэхүү этгээд нь хөрөнгө оруулалт хийхэд эрсдэл бүхий этгээдэд тооцогдоно:

4.1. Даатгалын тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан холбогдох этгээд;

4.2. Даатгагчийн болон холбогдох этгээдийн хувь нийлүүлэгч болон хувьцаа эзэмшигч;

4.3. Даатгалын компанийн хувь нийлүүлэгч, ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, даатгалын салбарын захирал, тэдгээрийн өвөг эцэг, эмэг эх, эцэг, эх, эхнэр, нөхөр, ах, эгч, дүү, хүүхэд болон тэдэнд хяналтын багцаа эзэмшүүлдэг хуулийн этгээд, уг хуулийн этгээдийн хяналтын багцыг эзэмшдэг аливаа иргэн, хуулийн этгээд;

4.4. Барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нь зээлийн үндсэн өр болон хүүгийн төлбөрийг барагдуулахад хүрэлцэхгүй байгаа иргэн, хуулийн этгээд;

4.5. Холбогдох этгээдтэй хэрэг, маргаан үүссэний улмаас эрх бүхий байгууллагаар хянагдаж, шалгагдаж байгаа этгээд;

4.6. Тухайн даатгалын компанийн даатгуулагч;

4.7. Даатгалын компани өөрөө холбогдох этгээд гэж үзсэн бусад этгээд.

Тав. Хяналт тавих

5.1. Энэ журмын нэгдүгээр болон хоёрдугаар хавсралт болох “Маягт-1, 2”-оор төлбөрийн чадвараа тооцож гарган улирал бүр санхүүгийн тайлангын хамт Хороонд ирүүлнэ.

5.2. Энэ журамд заасны дагуу даатгагч төлбөрийн чадваргүй болж болзошгүй болсон, эсхүл төлбөрийн чадваргүй болсон бол энэ талаар Хороонд нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

5.3. Хороо энэ журмын хэрэгжилтэд байнга хяналт тавих бөгөөд зөрчсөн этгээдэд Даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

“Ердийн даатгагчийн төлбөрийн чадварын тооцох журам”-ын нэгдүгээр хавсралт “МАЯГТ-1”

“..... “ ХХК-ийн 20... оны дүгээр улирлын зөвшөөрөгдөхгүй хөрөнгийг тооцох аргачлал //Энэ аргачлалд Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 498 дугаар тогтоолоор нэмэлт орсон/ /Энэ заалтанд Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 343 дугаар тогтоолоор нэмэлт орсон/

Хөрөнгийн ангилал	Хөрөнгийн байршуулах дээд хувь	Нийт хөрөнгийн зөвшөөрөгдөхгүй дүн	Нэгжид ногдох хөрөнгө байршуулах дээд хувь	Нэгжид ногдох тухайн хөрөнгийн зөвшөөрөгдөхгүй	Зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн хувь	Зөвшөөрөгдөх хөрөнгийг бууруулах дүн	Нийт зөвшөөрөгдөхгүй дүн
Баганын дүн	1	2	3	4	5	6	7=2+4+6
1 Банкны харилцах, хадгаламж	100%		35%		0%		
1 ¹ Даатгалын үндсэн үйл ажиллагаанд зориулан авсан зээл	30% *		30% *		50%		
2 Засгийн газраас гаргасан өрийн хэрэгсэл	100%		100%		0%		
3 Банкны хадгаламжийн сертификат	50%		20%		0%		
4 Төв банкны үнэт цаас	100%		100%		0%		
5 Бэлэн мөнгө	2%		2%		0%		
6 180 хоногоос доошхи хугацаатай авлага	20%		20%		0%		
7 Санхүүгийн түрээс	10%		5%		5%		
8 Үл хөдлөх хөрөнгө	25%		25%		5%		
9 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	60%		20%		5%		
10.Хөрөнгө оруулалтын сан /Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 6.2.1-д заасан нээлттэй, эсхүл хаалттай санг ойлгоно./ <i>/Энэхүү заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 279 дүгээр тогтоолоор өөрчилсөн./</i>	20%		10%		Нээлттэй сан: 5% Хаалттай сан: 10%		
11 Аймаг нийслэлийн гаргасан өрийн хэрэгсэл	60%		20%		10%		

12 Компанийн өрийн хэрэгсэл	20%		10%		10%		
13 Эд хогшил тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл	10%		5%		90%		
13 ¹ .МХБ-ийн хувьцаат компанийн хувьцаа <i>/Энэхүү заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 279 дүгээр тогтоолоор өөрчилсөн/</i>	I ангилал	10%			20%		
	II ангилал	5%		5%	30%		
13 ² .Тухайн даатгалын компанийн холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө <i>/Энэхүү заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 279 дүгээр тогтоолоор өөрчилсөн./</i>		20%		5%	5%		
14 Бусад авлага	0%				100%		
15 Биет бус хөрөнгө	0%				100%		
16 Бараа материал	0%				100%		
17 Урьдчилж төлсөн зардал	0%				100%		
18 Бусад хөрөнгө	0%				100%		
Нийт дүн							

*Хувь нийлүүлсэн хөрөнгө буюу дүрмийн сангийн хөрөнгөөс тооцно.

Тайлбар: 2 дугаар баганыг тооцохдоо баланс дахь тухайн хөрөнгийн дүнгээс нийт хөрөнгийн хэмжээ ба 1 дүгээр баганын харгалзах дүнгийн үржвэрийг хасч, гарсан дүн нь нэмэх тэмдэгтэй гарсан тохиолдолд тухайн дүнгээр тусгана.

4 дүгээр баганыг тооцохдоо баланс дахь тухайн хөрөнгийн нэгжид ногдох дүнгээс нийт хөрөнгийн хэмжээ ба 3 дугаар баганын харгалзах дүнгийн үржвэрийг хасч, гарсан дүн нь нэмэх тэмдэгтэй гарсан тохиолдолд тухайн дүнгээр тусгана.

6 дугаар баганыг тооцохдоо энэ хүснэгтийн 1 дүгээр багана буюу хөрөнгийн байрилын зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа хөрөнгийг 5 дугаар баганад заасан хувиар үржүүлж тооцно.

7 дугаар баганын дүн нь 2 дугаар багана, 4 дүгээр багана, 6 дугаарын баганын дүн тус бүрийн нийлбэр нь байна.

*“Ердийн даатгагчийн төлбөрийн чадварын тооцох журам”-ын хоёрдугаар хавсралт
“МАЯГТ-2”*

**“..... “ ХХК-ийн 20... оны дүгээр улирлын
төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт**

<i>1. Зайлиггүй байх хөрөнгө / $1 = \max(1.1, 1.2, 1.3)$ /</i>				
Үзүүлэлт		Дүн	Тооцох хувь	Тооцсон дүн
	1	2	3	4
1.1 Даатгалын хураамжид үндэслэх /Тухай тайлант хугацааны нийт орлогод тооцсонхураамж / $(1.1.1 (4)+1.1.2 (4))$				
	1.1.1 Агаарын хөлөг, авто тээврийн хэрэгсэл, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн орлогод тооцсон хураамж		40%	
	1.1.2 Бусад хэлбэрийн орлогод тооцсон хураамжийн 20%		20%	
1.2 Даатгалын нэхэмжлэлд үндэслэх /Сүүлийн 3 жилийн дунджид үндэслэн/ $(1.2.1 (4)+1.2.2 (4))$				
	1.2.1 Агаарын хөлөг, авто тээврийн хэрэгсэл, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн нөхөн төлбөр * 50%		50%	
	1.2.2 Бусад хэлбэрийн нөхөн төлбөр * 20%		20%	
1.3 Хорооноос тогтоосон дүрмийн сангийн доод хэмжээ				
<i>2. Нийт хөрөнгө</i>				
<i>3. Зөвшөөрөгдөхгүй хөрөнгө</i>				
<i>4. Зөвшөөрөгдөх хөрөнгө / $4 = (2) - (3)$ /</i>				

5. Өр төлбөр / 5=урт хугацаат өр төлбөр+богино хугацаат өр төлбөр-ОТХ*10%/		
6. Төлбөрийн чадварын зохистой харьцаа 6= (4-5)/1≥100%		

--ooOoo--